

**ҮНЭТ ЦААСААРХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БҮРТГЭЛ,
ТАЙЛАГНАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ**

Д.Нямаа

Хөрөнгө оруулалтын төрөл, ангилал

Хүү, лицензийн төлбөр, ноогдол ашиг болон түрээсийн төлбөр авах зэргээр ашиг олох, хөрөнгөө нэмэгдүүлэх, өмч буюу капиталынхаа үнэ цэнийг өсгөх зорилгоор аж ахуйн нэгжийн эзэмшиж байгаа, үндсэн үйл ажиллагаагаар шууд тодорхойлогдохгүй хөрөнгийг хөрөнгө оруулалт / investment / гэдэг.

Хөрөнгө оруулалтыг эзэмшиж байгаа хугацаагаар нь богино ба урт хугацаат, хэлбэрийнх нь хувьд үнэт цаасаарх, мөнгөн хөрөнгөөрх, тусгай зорилго бүхий сангаарх, биет хөрөнгөөрх капитал оруулалт гэж тус тус ангилна.

Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтыг бусад компанийн хувьцаа болон хувьцааны эрхээрх буюу өмчийн үнэт цаасаарх капитал оруулалт, бондоорх буюу өрийн үнэт цаасаарх капитал оруулалт гэж ангилдаг.

Урт хугацаат хөрөнгө оруулалтанд худалдан авсан эргэлтийн бус өмчийн үнэт цаас буюу хувьцаа, хувьцааны эрх, бонд, вексель, хувьцаа худалдан авах, бонд эргэлтээс гаргах зэрэг бусад зорилго бүхий сан, үнэ цэнийг өсгөх зорилгоор эзэмшиж байгаа биет үндсэн хөрөнгө, бусад аж ахуйн нэгжид оруулсан өмч болон амь даатгалын мөнгөн үнэлгээ зэрэг хөрөнгүүд багтана.

Бондоорх хөрөнгө оруулалт / Investment in bonds/-ын буртгэл

Бондоорх хөрөнгө оруулалтыг худалдан авсан өдөр өртгөөр нь бүртгэнэ. Хөрөнгө оруулалтын өртөг буюу худалдан авалтын үнэ нь холбогдох эрсдлийн зах зээлийн үнэлгээ ба тухайн төрлийн үнэт цаасны зах зээлийн давамгайлах хүүний түвшинтэй харьцуулах тогтоосон хүүгээр тодорхойлогдох капитал оруулалтын зах зээлийн үнэ юм. Хөрөнгө оруулагчийн хүсч байгаа өгөөж бонд гаргагчийн тогтоосон хүйтэй тэнцүү байвал бонд нэрлэсэн үнээрээ, хөрөнгө оруулагч

тогоосон хүүнээс илүү өгөөж шаардаж байвал бонд хөнгөлөлттэй борлогдоно.

Хэрвээ, хүүний зах зээлийн түвшин нь тогоосон хүүнээс бага байвал хөрөнгө оруулагч бондын дуусгавар болох үнэ цэнээс илүү дүн буюу урамшуулалт төлдөг. Бондын зах зээлийн үнэ нь дуусгавар болох дүнгийн өнөөгийн үнэ цэнэ дээр хүүний төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг нэмсэн дүн юм. 8% хүйтэй, хүүг хагас жил тутам төлөх, 6 жилийн хугацаатай 600000 төг.ийн бондын зах зээлийн үнэ зах зээлийн хүү 10% байхад хэд байх вэ? гэвэл:

Бондоорх хөрөнгө оруулалтын өртөг =Дуусгавар болгох дүнгийн өнөөгийн үнэ цэнэ+Хүүний төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнэ= $(600000 \times P/F, 12.5\%, 6) + 24000 \times P/A, 12.5\%, 6 = 600000 \times 0.55684 + 24000 \times 8.86325 = 546822$ төг болно.

Бондыг хүүний төлбөрийн өдрүүдийн хооронд худалдан авсан бол хөрөнгө оруулагч нь бондын зах зээлийн үнэн дээр хүүний төлбөрийн сүүлийн өдрөөс хойш хуримтлагдсан хүүг нэмсэн дүнгээр төлбөр хийнэ.

Жишиг нь:

“Бүрэн” ХК 1000000 төг.ийн нэрлэсэн үнэтэй, 6% хүйтэй, 3-р сарын 1 ба 9-р сарын 1-нд хүүгээ төлдөг, 2013 оны 3-р сарын 1-нд дуусгавар болох бондыг 2005 оны 5-р сарын 1-нд зах зээлийн үнэ нь 1200000 төг байх үед худалдаж авсан гэе.

2005 оны 5-р сарын 1-нд хийгдэх дансны бичилт нь:

Бондоорх хөрөнгө оруулалт 1200000

Хүүний орлого 10000

Мөнгөн хөрөнгө 1210000

3-р сарын 1-ээс 5-р сарын 1 хүртэлх хугацаанд хуримтлагдсан хүү нь $1000000 \times 6\% \times 2 / 12 = 10000$ төг болж байна.

Хөрөнгө оруулагч цаашид хүүний орлого авах бүрдээ хөрөнгө оруулалтынхаа урамшууллыг хорогдуулж бүртгэнэ. Урамшууллын хорогдуулгын дүнг шулуун шугамын эсвэл үр ашигт хүүний аргаар (өнөөгийн үнэ цэнийн арга, нийлмэл хүүний арга, зах зээлийн үнийн арга ч гэж нэрлэдэг) тооцдог.

9-р сарын 1-нд хүүний төлбөр авах өдөр урамшууллын хорогдуулгыг шулуун шугамын аргаар тооцвол дараах бичилтийг хийнэ.

Мөнгөн хөрөнгө 30000

Хүүний орлого 21489

Бондоорх хөрөнгө оруулалт 8511

2005 оны 5-р сарын 1-ээс 2013 оны 3-р сарын 1 хүртэл 7 жил, 10 сар буюу 94 сарын хугацаа байгаа тул 5-р сарын 1-ээс 9-р сарын 1 хүртэлх 4 сард ноогдох урамшууллын хорогдуулгын дүнг шулуун шугамын аргаар тооцсон дүн нь $200000 \times 4 / 94 = 8511$ төг байгаа юм.

Бондоорх хөрөнгө оруулалтын урамшуулал болон хөнгөлөлтийг хорогдуулсан дүнгээр бондын дансны үнэ өөрчлөгддэг. Тайлант үе бүрд хөрөнгө оруулалтын дансны үнийг хөнгөлөлтийн хорогдуулгын дүнгээр нэмэгдүүлж урамшууллыг хорогдуулсан дүнгээр бууруулна.

Бондоорх хөрөнгө оруулалтын урамшуулал болон хөнгөлөлтийг үр ашигт хүүний аргаар хэрхэн хорогдуулж бүртгэхийг жишээгээр авч үзье.

“Золбоо” ХК 2005 оны 12-р сарын 31-нд 1000000 төг.ийн нэрлэсэн үнэтэй, 7% хүйтэй 5 жилийн хугацаатай бондыг зах зээлийн хүү 5% байхад 1086600 төг.өөр худалдан авч хөрөнгө оруулалт хийсэн. Хүүг жил бүрийн эцэст авна гэе.

Хүүний орлого ба бондын урамшууллын хорогдуулгын хөтөлбөр

Үр ашигт хүүний арга

(5 жилийн хугацаатай, 7% хүйтэй бондыг 5% өгөөжтэй худалдаж авсан)

Огноо Тогоосон хүү Үр ашигт хүү Урамшууллын Хорогдуулсан Хорогдуулга өртөг

	2005.12.31		1086600
2006.12.31	70000	54330	1070930
2007.12.31	70000	53546,5	1054476,5
2008.12.31	70000	52723,8	1037200,3
2009.12.31	70000	51860	1019060,3
2010.12.31	70000	50953	1000000
Дүн	<u>350000</u>	<u>263413,3</u>	<u>86586,7</u>

2005 оны 12-р сарын 31-нд бонд худалдаж авсны дансны бичилт:

Бондоорх хөрөнгө оруулалт 1086600

Мөнгөн хөрөнгө 1086600

2006 оны 12-р сарын 31-нд хүүний орлогоо бүртгэх үед

Мөнгөн хөрөнгө 70000

Бондоорх капитал оруулалт 15670

Хүүний орлого 54330 гэж бичнэ.

2007 оны 12-р сарын 31-нд хүүний орлого авах үед хийгдэх дансны бичилт:

Мөнгөн хөрөнгө 70000

Бондоорх капитал оруулалт 16453,5

Хүүний орлого 53546,5

Бондоорх хөрөнгө оруулалтыг дуусгавар хугацаанаас нь өмнө борлуулах

Үр хугацаат бондоорх хөрөнгө оруулалт гэж бүртгэсэн бондыг дуусгавар хугацаанаас өмнө борлуулбал борлуулалтын өдөр хорогдуулга тооцогдоогүй хөнгөлөлт эсвэл урамшууллыг хорогдуулж, борлуулсан бондын дансны үнийг хөрөнгө оруулалт данснаас хасах бичилт хийх ёстой.

2005 оны 12-р сарын 31-нд худалдаж авсан бондоо 2007 оны 6-р сарын 30-нд 1100000 төг дээр хуримтлагдсан хүүг нэмснээр борлуулсан гэж үзье.

2006 оны 12-р сарын 31-ээс 2007 оны 6-р сарын 30 хүртэлх хугацааны хорогдуулга тооцогоогүй урамшууллын дүн нийт оролцоогоор $16453,5/2=8227$ төг болсон гэж үзвэл бондоорх хөрөнгө оруулалтаа борлуулсыг бүртгэх дансны бичилт:

Мөнгөн хөрөнгө	35000
Хүүний орлого	26773
Бондоорх хөрөнгө оруулалт	8227
Мөнгөн хөрөнгө	1100000
Бондоорх хөрөнгө оруулалт	1062703
Бондоорх хөрөнгө оруулалт борлуулалтын олз	37297

Хувьцаагаарх хөрөнгө оруулалт /Investment in stocks/-ын бүртгэл

Хувьцааг нээлттэй зах зээл дэх компаниудын хувьцаа эзэмшигчдээс, хувьцаа гаргасан компаниас, эсвэл брокероос худалдан авч болох юм. Хувьцааг мөнгөөр худалдан авч хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд өртөгт нь хувьцааг худалдан авсан үнэ, хувьцаа худалдан авалттай холбоотой бусад зардлуудыг оруулж бүртгэнэ. Хувьцааг зээлээр буюу үнийг нь дараа төлөх нөхцлөөр худалдан авсан ч бүрэн өртгөөр нь бүртгэх ба хувьцаа худалдан авалтаас бий болсон өглөгийн хүүг зардлаар бүртгэдэг. Мөнгөн бус хөрөнгө, эсвэл үйлчилгээний солилцоогоор авсан хувьцааны өртгийг өгсөн хөрөнгийн зах зээлийн үнэ болон авсан хувьцааны зах зээлийн үнийн аль илүү тодорхой дүнгээр бүртгэнэ. Хоёр болон хэд хэдэн ангиллын үнэт цаасыг бөөнд нь худалдаж авбал үнэт цаасны ангилал тус бүрийн хувьд зах зээлийн үнэ мэдэгдэж байгаа бол зах зээлийн үнэнд үндэслэн өртгийг хуваарилна.

Санхүүжүүлэгч гэгдэх нэг компани нөгөө компанийн энгийн хувьцаан дахь хувь оролцоог худалдан авсан хэмжээ нь ерөнхийдөө хөрөнгө оруулалтын бүртгэлийн аргыг тодорхойлдог.

Нэг компани нөгөө компанийн саналын эрхтэй хувьцааны 50-иас илүү хувийг худалдаж авсан бол хөрөнгө оруулагч буюу санхүүжүүлэгчийг **хяналтын хувь оролцоотой** гэх ба СТОУС-3-т тодорхойлсноор хяналт гэдэг нь бизнесийн байгууллагын санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааг өгөөжтэй байхаар удирдан зохицуулах эрх юм. Энэ нөхцөлд хөрөнгө оруулагчийг толгой компани, санхүүжигчийг охин компани гэж нэрлэнэ. Охин компанийн энгийн хувьцаан дахь хөрөнгө оруулалтыг толгой компанийн тусдаа санхүүгийн тайланд урт хугацаат хөрөнгө оруулалт байдлаар харуулах ба толгой ба охин компанийг багтаасан группийн хувьд нэгдсэн санхүүгийн тайлан гаргадаг байна.

Хөрөнгө оруулагч компани санхүүжигч компанийн энгийн хувьцааны 20-50%-ийг худалдаж авсан нөхцөлд санхүүжүүлэгчийг санхүүжигчид

мэдэгдэхүйц нөлөөтэй гэж үзэх ба капитал оруулалтыг өмчийн буюу капиталын аргаар бүртгэнэ. НББОУС-28-д: "...мэдэгдэхүйц нөлөөлөл гэдэг нь санхүүжигчийн санхүүгийн болон үндсэн үйл ажиллагааны бодлогыг тодорхойлоход оролцох бөгөөд бодлогод хяналт тавихгүй байх эрх юм.

Доор дурдагдсан нэг эсвэл хэд хэдэн арга замууд нь хөрөнгө оруулагчийн мэдэгдэхүйц нөлөөтэй байгааг баталж өгдөг. Үүнд:

- а. Санхүүжүүлэгчийн захирлуудын зөвлөлд буюу үүнтэй адилтгах удирдлагын байгууллагад төлөөлөлтэй бол,
- б. Бодлого боловсруулах үйл ажиллагаанд оролцдог бол,
- в. Санхүүжигч болон хөрөнгө оруулагчийн хооронд материаллаг хэмжээний ажил гүйлгээ гардаг бол,
- г. Удирдлагынхаа албан хаагчдыг харилцан солилцдог бол,
- д. Техник-эдийн засгийн чухал мэдээллээр хангадаг бол " гэж тодорхойлсон байдаг.

Хөрөнгө оруулагч нь санхүүжигчийнхээ саналын эрхтэй хувьцааны 20% ба түүнээс бага хувийг шууд эсвэл, охин компаниудаараа дамжуулан шууд бусаар эзэмшиж байгаа бол хөрөнгө оруулагч нь **мэдэгдэхүйц нөлөөлөлгүйг** илтгэдэг. Энэ нөхцөлд хөрөнгө оруулалтыг өргтийн аргаар бүртгэнэ.

Өмчийн буюу капиталын аргын дагуу хөрөнгө оруулалтыг эхлээд өртгөөр нь бүртгэж худалдан авсны дараагийн үеүдэд санхүүжигчийн ашиг эсвэл алдагдлаас хөрөнгө оруулагчид ноогдох хувийг үндэслэн хөрөнгө оруулалтын дансны үнийг нэмэгдүүлэх эсвэл хорогдуулж бүртгэдэг. Мөн, санхүүжигчээс хүлээн авсан ноогдол ашгийн дүнгээр хөрөнгө оруулалтын дансны үнийг хорогдуулна.

Өртгийн арга гэдэг нь хөрөнгө оруулагч нь санхүүжигч компанийд оруулсан хөрөнгө оруулалтаа өртгөөр нь бүртгэдэг арга юм. Зөвхөн хувьцаа худалдан авсан өдрөөс хойши хүеүдэд бий болсон санхүүжигчийн хуримтлагдсан цэвэр ашгийн хуваарилалтаас хөрөнгө оруулагчийн хүлээн авсан дүнг л хөрөнгө оруулалтаас хүлээн авсан орлого гэж орлого үр дүнгийн тайланд тусгана.

Урт хугацаат хувьцаагаарх хөрөнгө оруулалтыг бүртгэх өмчийн болон өртгийн аргыг хэрхэн хэрэглэхийг жишээгээр авч үзье.

"Цэцэг" ХК "Дэлбээ" ХК-ийн гүйлгээнд байгаа энгийн хувьцааны 20%-ийг худалдаж авсан гэж үзье. Өртгийн аргыг хэрэглэх зорилгоор "Цэцэг" компани "Дэлбээ" компанийд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй, харин өмчийн буюу капиталын арга хэрэглэх нөхцөлд хувьцаан дахь 20% оролцоо нь мэдэгдэхүйц нөлөөтэй гэж тооцье.

* 2005 оны 1-р сарын 2-нд "Цэцэг" компани "Дэлбээ" компанийн 100 төгийн нэрлэсэн үнэтэй 5000 ш энгийн хувьцаанаас 1000 ш-ийг нэг

бүрд нь холбогдох зардлуудыг оролцуулан 120 төг.өөр худалдан авч капитал оруулалт хийв.

Дансанд бичвэл:

Өргийн арга	Өмчийн арга
Хувьц/-х хөрөнгө оруулалт 120000	Хувьц/-х хөрөнгө оруулалт 120000
Мөнгөн хөрөнгө 120000	Мөнгөн хөрөнгө 120000
1000x120 төг=120000	

* “Дэлбээ” компани гүйлгээнд байгаа энгийн хувьцаа бүрдээ 90 төг.ийн мөнгөн ноогдол ашиг олгооор зарласан.

Ноогдол ашгийн авлага 90000 Ноогдол ашгийн авлага 90000
Ноогдол ашгийн орлого 90000 Хувьц/-х хөрөнгө оруулалт 90000
1000x90 төг=90000

* Тайлант онд “Дэлбээ” компани 900000 төг.ийн цэвэр ашигтай ажилласан.
Хувьц/-х хөрөнгө оруулалт 180000
Хөрөнгө оруулалтын олз 180000

900000X20%=180000

* Санхүүгийн тайлан гаргахаар тасалбар болгосон өдөр буюу балансын өдөр “Дэлбээ” компанийн нэгж хувьцааны зах зээлийн үнэ 116 төг байв.
Хөрөнгө оруулагч санхүүжигчид мэдэгдэхүйц нөлөөгүй нөхцөлд хувьцаагаарх хөрөнгө оруулалтаа тайлагнаадаа **өртөг ба зах зээлийн үнийн аль бага** аргыг хэрэглэдэг. Урт хугацаат хувьцаагаарх хөрөнгө оруулалтын багцын зах зээлийн үнээс өртгийн давсан дүнг үнэлгээний хэрэгжээгүй гарз болон үнэлгээний хасагдуулга гэж тайлагнана.

“Цэцэг” компанийн “Дэлбээ” компани дахь хувьцаагаарх хөрөнгө оруулалтын өртөг нь 120000 төг, зах зээлийн үнэ нь 116000 төг болж байгаа учир хөрөнгө оруулалтыг 116000 төг.өөр тайлагнах ба дараах тохиргоо бичилтийг хийнэ.

Хувьцаагаарх хөрөнгө оруулалтын үнэлгээний хэрэгжээгүй гарз 4000
Хөрөнгө оруулалтын үнэлгээний хасагдуулга 4000

Хувьцааны эрхээрх хөрөнгө оруулалт / Investment in stock rights/-ын бүртгэл

Компани гүйлгээнд байгаа хувьцаандаа нэмж хувьцаа гаргаж борлуулах нөхцөлд хувьцаа эзэмшигчиддээ одоогийн эзэмшилтэй нь шууд хамааралтайгаар нэмэлт хувьцаа худалдаж авахыг зөвшөөрсөн гэрчилгээг олгож болно. Гэрчилгээ нь нэмж хувьцаа худалдаж авах эрхийг илэрхийлдэг ба түүнийг **хувьцааны эрх** гэж нэрлэдэг. Ерөнхийдөө нэг хувьцаанд нэг эрх гэсэн суурь байдаг боловч нэг шинэ хувьцаа худалдаж авахад хэд хэдэн эрх шаардагдаж болно. Хувьцааны эрхийг илэрхийлэх гэрчилгээг баталгаа гэж нэрлэх бөгөөд баталгаа нь эрх эзэмшигчийн худалдан авч болох хувьцааны тоо ба худалдан авах үнийг харуулдаг. Хэрвээ нэмэлт хувьцаа худалдаж авах үнэ нь уг хувьцааны одоогийн зах зээлийн үнээс бага бол хувьцааны эрх тусдаа. үнэ цэнэтэй байна. Эрхийг бусад үнэт цаасны адилаар

худалдан авч борлуулж болно. Хувьцааны эрхтэй холбоотой 3 хугацаа байдаг.

1. Эрх санал болгож байгааг зарлах өдөр
2. Эрх буюу гэрчилгээг гаргасан өдөр
3. Эрхийн хугацаа дуусах өдөр

Эрхийг зарласнаас гаргах хүртэлх хугацаанд хувьцаа ба эрхийг салгах боломжгүй байдаг бөгөөд хувьцааг эрхтэй гэж үзнэ. Эрхийг хүлээн авснаас хүчингүй болох хүртэлх хугацаанд хувьцаа ба эрхийг тусад нь борлуулж, худалдаж авч болно.

Эрх авсан хөрөнгө оруулагч дараах боломжийг эдэлдэг. Үүнд:

Эрхээ хэрэгжүүлэх замаар нэмэлт хувьцаа худалдаж авах, эрхээ худалдан борлуулах, хүчингүй болгох зэрэг болно.

Эрх авах үед өмнө нь эзэмшиж байсан хувьцаа эрхтэй болох ба анх эзэмшиж байсан хувьцааны дансны үнэ хувьцаа ба эрхэд хуваарилагдана.

Хөрөнгө оруулагч хувьцааны эрхээ худалдан борлуулбал эрхийн дансны үнийг борлуулсан үнэтэй харьцуулж борлуулалтын олз, эсвэл гарзыг тодорхойлж бүртгэх ба хувьцааны өртгийг хувьцаа ба эрхэд хуваарилахдаа эрх хүлээн авах үеийн хувьцаа ба эрхийн нийт зах зээлийн үнэнд үндэслэнэ

Хувьцааны эрхээрх хөрөнгө оруулалтын бүртгэл тооцооллыг жишээгээр авч үзье.

Компани хувьцааны эрх авахын өмнө ”Амар” компанийн нэгжийн 250 төг.ийн өртөгтэй 500 ш хувьцааг эзэмшиж байв. Эрх авснаар эзэмшиж байгаа хувьцаа бүр 1 эрхтэй болсон ба шинээр авах хувьцаа бүрд 2 эрх шаардагдана гээ.

Эрх авах үеийн нэгж хувьцааны зах зээлийн үнэ 300 төг, нэгж эрхийн зах зээлийн үнэ 15 төг байсан гэвэл:

Хувьцааны зах зээлийн үнэ 500 ш x300 төг=150000 төг, Эрхийн зах зээлийн үнэ 500 ш x15 төг=7500 төг, хувьцаа ба эрхийн нийт зах зээлийн үнэ 157500 төг болно.

Хувьцаанд хуваарилагдах өртөг=150000/157500 x125000=119048 төг

Эрхэд хуваарилагдах өртөг=7500/157500 x 125000=5952 төг

Холбогдох дансны бичилтийг хийе.

Эрх хүлээн авсныг бүртгэвэл:

Хувьцааны эрхээрх хөрөнгө оруулалт 5952
Хувьцаагаарх хөрөнгө оруулалт 5952

Эзэмшиж байсан хувьцаанаасаа 50 ш-ийг нэг бүрийг нь 290 төг.өөр борлуулсан гэвэл:(Эрх авснаас хойш нэгж хувьцааны өртөг 119048/500=238 төг болсон)

Мөнгөн хөрөнгө 14500 /50x290/

Хувьцаагаарх хөрөнгө оруулалт 11900 /50x238/

Хөрөнгө оруулалт борлуулсны олз 2600 /50x(290-238)/

200 ш эрхээ нэгжийг нь 15 төг.өөр борлуулсан гэвэл:

Мөнгөн хөрөнгө	3000	/ 200x15/
Хувьцааны эрхээрх хөрөнгө оруулалт	2380	/ 200x11,9/
Хөрөнгө оруулалт борлуулсны олз	620	/ 200x (15-11,9)/
100 ш хувьцаа худалдан авах эрхээ хэрэгжүүлж, хувьцаа бүрд 250 төг төлснөөр хувьцаа худалдан авсан гэвэл:		
уувьцаагаарх хөрөнгө оруулалт	27380	/100 x250 +200 x 11,9/
Мөнгөн хөрөнгө	25000	/ 100x 250/
Хувьцааны эрхээрх хөрөнгө оруулалт	2380	/ 200x11,9/
Үлдсэн 100 ш эрхийн хушгацаа дууссан тул хүчингүй болсон гэвэл:		
Хувьцааны эрх дуусалтын гарз	1190	
Хувьцааны эрхээрх хөрөнгө оруулалт	1190	

Хөрөнгө оруулалтын үзүүлэлтээрх тайлагнал, тодруулга

Үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын үндсэн ангилал болон тэдгээрийн тайлагналын шаардлагыг нэгтгэн авч үзвэл дараах байдалтай байна.

Өрийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт**/Investments in debt securities/**

Ангилал Classification	Баланс дахь тайлагнал Presentation in Balance Sheet	Орлогын тайлан дахь тайлагнал Presentation in Income Statement
Худалдааны /Held for trading/	Хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнээр харуулна. Эргэлтийн хөрөнгөнд тайлагнана.	Хүүг орлогод тооцно. Хэрэгжсэн (борлуултаас үүссэн) болон хэрэгжээгүй (үнэлгээний) олз, гарзыг ашгийн тооцоололд оруулдаг.
Борлуулахад бэлэн байгаа /Available-for-sale/	Хөрөнгө оруулалтыг зах зээлийн үнэ буюу бодит үнээр эргэлтийн эсвэл эргэлтийн бус хөрөнгөнд харуулна. Үнэлгээнээс үүссэн хэрэгжээгүй олз, гарзыг бусад ашиг гэж үзэн хувьцаа эзэмшигчдийн өмчийн бүрэлдэхүүн үзүүлэлт болгож харуулна.	Хүүг орлогод тооцно. Хэрэгжсэн (борлуултаас үүссэн) олз, гарзыг цэвэр ашгийн тооцоололд оруулдаг. Үнэлгээнээс үүссэн хэрэгжээгүй олз, гарзыг цэвэр ашгийн тооцоололд оруулахгүй бусад ашгаар тайлагнана.
Дуусгавар хугацаа хүртэл эзэмшиж байгаа /Held-to-maturity/	Хөрөнгө оруулалтыг хорогдуулсан өртгөөр харуулна. Хэрэгжээгүй олз, гарзыг тооцдоггүй. Эргэлтийн ба эргэлтийн бус хөрөнгөнд тайлагнана.	Хүүг орлогод тооцно. Борлуулалтаас үүссэн олз, гарзыг ашгийн тооцоололд оруулна.

**Өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалт
/Investments in equity securities/**

Хувьцаагаарх хөрөнгө оруулалтын ангилал	Үнэлгээ	Үнэлгээний хэрэгжээгүй олз эсвэл гарз	Ашиг дахь бусад нэлэө
20%-иас бага хувийг эзэмшиж байгаа 1.Борлуулахад бэлэн байгаа /Available-for-sale/	Бодит үнэ буюу зах зээлийн үнэ	Бусад ашиг гэж үзэх ба хувьцаа эзэмшигчдийн өмчийн бүрэлдэхүүн үзүүлэлт болгож харуулна.	Зарласан ноогдол ашиг, борлуулалтын олз болон гарз
2.Худалдааны /Held for trading/	Бодит үнэ буюу зах зээлийн үнэ	Цэвэр ашгийн тооцоололд оруулна	Зарласан ноогдол ашиг, борлуулалтын олз болон гарз
20%-50% эзэмшиж байгаа	Өмчийн арга	Тодорхойлохгүй	Санхүүжигчийн цэвэр ашиг эсвэл цэвэр алдагдал дахь оролцооны хувь, борлуулалтын олз болон гарз
50%-аас илүүг эзэмшиж байгаа	Нэгтгэх	Тодорхойлохгүй	Авч үздэггүй

Санхүүгийн тайлангийн тодруулга хэсэгт балансын өдрөөрх өмчийн үнэт цаасаарх хөрөнгө оруулалтын нийт өртөг ба нийт зах зээлийн үнэ, хөрөнгө оруулалтын үнэлгээний хэрэгжээгүй олз болон гарз, борлуулснаас үүссэн хэрэгжсэн олз, гарзын талаарх мэдээллийг харуулах шаардлагатай байдаг.